



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/002/НА-СТА-ТТЗ

|   |  |
|---|--|
| Цахим хуудас:<br><a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 7036-3040<br>Цахим хаяг: <a href="mailto:Enkhtuyach@audit.gov.mn">Enkhtuyach@audit.gov.mn</a> |
| Сүхбаатар сум<br>2025 он  | Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 7036-3036<br>Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a>            |
|   | Аудитор: Б.Наранцэцэг<br>Утас: 7036-2442<br>Цахим хаяг: <a href="mailto:Narantsetsegba@audit.gov.mn">Narantsetsegba@audit.gov.mn</a>       |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

|   |       |
|---|-------|
| 1. Аудитын дүгнэлт  | 4-6   |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл                  | 7-12  |
| 3. Санхүүгийн тайлангийн тодруулга                                    | 13-22 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа                                 | 13    |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин                                 | 13-14 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал                             | 14    |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт | 15-17 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв                        | 18-22 |
| 4. Аудитын тайлан   | 22-26 |
| 4.1 Ерөнхий зүйл  | 22    |
| 4.2 Материаллаг байдал  | 23    |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт                         | 23    |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал  | 24    |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт                | 25    |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал                               | 25    |
| 5. Аудитын илрүүлэлт  | 26-30 |
| 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл                        | 31-32 |

### **Товчилсон үгийн жагсаалт**

|              |   |
|--------------|---|
| АДБОУС       | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт   |
| БТСГ         | Биеийн тамир спортын газар  |
| БХНС         | Байгаль хамгаалах нөхөн сэргээх   |
| ЗДНХ         | Засаг даргын нөөц хөрөнгө   |
| ЗДТГ         | Засаг даргын Тамгын газар   |
| ИТХ          | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  |
| НДШ          | Нийгмийн даатгалын шимтгэл  |
| ОНЕО         | Орон нутгийн ерөнхий орлого   |
| ОНХО         | Орон нутгийн хөрөнгө оруулалт   |
| ОНХС         | Орон нутгийн хөгжлийн сан   |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай |
| ХХС          | Хоршоог хөгжүүлэх сан   |
| ХХОАТ        | Хувь хүний орлогын албан татвар   |
| ТТЗ          | Төсвийн төвлөрүүлэн захирагч  |
| ТЕЗ          | Төсвийн ерөнхийлөн захирагч   |



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

2025.03.25 № 001-2025/002/НА-ЭТ-ТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- ЗДТГ нь орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 8 албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас **5,335.3** мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй, **418.7** мянган төгрөгийн цалин хөлс, илүү олгосон,
- ЗДТГ, ИТХ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас **5,553.4** мянган төгрөгийн авлага, өр төлбөр үүсгэсэн боловч санхүүгийн тайланд тусгаагүй,
- ЗДТГ, ИТХ нь батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд гүйлгэн **12,874.5** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс **21,665.3** мянган төгрөгийг зориулалт бус зардлуудыг санхүүжүүлсэн,
- Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг зөрчин Засаг даргын захирамжаар видео контент хийлгэхээр "Монголын баялаг өв соёл ХХК"-тай гэрээ байгуулан **3,879.6** мянган төгрөгийн төлбөр шилжүүлсэн боловч гэрээт ажлыг хүлээн аваагүй гэх мэт.

#### **Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг**

Баянгол сумын ИТХ-ын "Сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай" 110 дугаар тогтоолоор тайлант онд 1,581,627.0 мянган төгрөгийн татварын орлого, 365,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт **1,946,627.0** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **2,746,859.5** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 41.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус байгууллагын урсгал зардалд тусгаж, хэрэгжүүлэх боломжтой ЗДТГ-т тоног төхөөрөмж худалдан авахад **20,000.0** мянган төгрөг, урсгал засварын зардлын **16,200.0** мянган төгрөг зэрэг 2 арга хэмжээг ОНХО-ын төсөвт баталж, хэрэгжүүлсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Баянгол сумын Засаг дарга нь тайлант онд 5 зорилт, 159 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.8 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код:  | Тайлангийн үзүүлэлт                         | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-------|---|------------------------|------------------------|
| 1     | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                     | 2,037,935.40           | 3,489,584.00           |
| 31    | МӨНГӨН ХӨРӨНГӨ                              | 943,021.00             | 1,736,602.10           |
| 33    | АВЛАГА                                      | 257,107.20             | 196,390.30             |
| 35    | БАРАА МАТЕРИАЛ                              | 837,807.20             | 1,556,591.60           |
| 2     | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                 | 4,784,836.40           | 5,385,422.30           |
| 39    | ҮНДСЭН ХӨРӨНГӨ                              | 4,784,836.40           | 5,385,422.30           |
| 39200 | Биет хөрөнгө                                | 4,680,596.60           | 5,276,484.20           |
| 39300 | Биет бус хөрөнгө                            | 104,239.80             | 108,938.20             |
| 3     | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II                 | 6,822,771.80           | 8,875,006.30           |
| 4     | НИЙТ ӨР ТӨЛБӨР                              | 67,036.70              | 66,661.20              |
| 41    | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                   | 67,036.70              | 66,661.20              |
| 41300 | Өглөг                                       | 67,036.70              | 66,661.20              |
| 5     | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                    | 6,755,735.10           | 8,808,345.10           |
| 51    | Засгийн газрын хувь оролцоо                 | 6,755,735.10           | 8,808,345.10           |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал             | 1,264,860.60           | 1,264,860.60           |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн                        | 4,014,236.40           | 6,066,846.50           |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү            | 1,476,638.00           | 1,476,638.00           |
| 6     | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 6,822,771.80           | 8,875,006.30           |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код:       | Тайлангийн үзүүлэлт                                      | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------------|--|------------------------|------------------------|
| <b>I</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                   | <b>4,284,129.50</b>    | <b>5,851,707.90</b>    |
| <b>11</b>  | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>                                   | <b>1,497,882.50</b>    | <b>2,251,162.40</b>    |
| 110        | Орлогын албан татвар                                     | 954,952.50             | 1,714,345.00           |
| 1100       | Хувь хүний орлогын албан татвар                          | 1,049,201.20           | 1,809,267.90           |
| 1101       | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт          | (94,248.70)            | (94,922.80)            |
| 113        | Хөрөнгийн албан татвар                                   | 326,258.10             | 241,056.80             |
| 118        | Бусад татвар, төлбөр, хураамж                            | 216,671.90             | 295,760.60             |
| <b>12</b>  | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                               | <b>1,671,014.80</b>    | <b>1,686,522.40</b>    |
| 120        | Нийтлэг татварын бус орлого                              | 1,671,014.80           | 1,686,522.40           |
| <b>13</b>  | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                     | <b>1,115,232.20</b>    | <b>1,914,023.10</b>    |
| <b>II</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                       | <b>2,016,840.90</b>    | <b>2,687,509.40</b>    |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>2,016,840.90</b>    | <b>2,687,509.40</b>    |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 1,976,644.30           | 2,630,996.20           |
| 2101       | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 624,697.70             | 999,792.80             |
| 2102       | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 78,096.70              | 109,951.60             |
| 2103       | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 82,235.20              | 549,781.30             |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 67,950.60              | 64,495.50              |
| 2105       | Нормативт зардал   | 2,100.00               | 2,100.00               |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 60,605.90              | 81,806.20              |
| 2107       | Томилолт, зочны зардал                                   | 5,375.20               | 6,385.30               |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 567,077.80             | 166,779.80             |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 488,505.20             | 649,903.60             |
| 213        | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 40,196.60              | 56,513.20              |
| <b>III</b> | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>             | <b>2,267,288.70</b>    | <b>3,164,198.50</b>    |
| <b>V</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                   | <b>868,527.80</b>      | <b>1,111,588.50</b>    |
| <b>VI</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>   | <b>1,398,760.90</b>    | <b>2,052,610.00</b>    |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|--|-----------------------|------------------------|
| 1    | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 5,356,974.20                           | 0.00                  | 5,356,974.20           |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0.00                                   | 0.00                  | 0.00                   |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 5,356,974.20                           | 0.00                  | 5,356,974.20           |
| 4    | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00                                   | 0.00                  | 0.00                   |
| 5    | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0.00                                   | 0.00                  | 0.00                   |
| 6    | Тайлант үеийн үр дүн                            | 1,398,760.90                           | 0.00                  | 1,398,760.90           |
| 7    | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 6,755,735.10                           | 0.00                  | 6,755,735.10           |
| 8    | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл             | 6,755,735.10                           | 0.00                  | 6,755,735.10           |
| 9    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0.00                                   | 0.00                  | 0.00                   |
| 10   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 0.00                                   | 0.00                  | 0.00                   |
| 11   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00                                   | 0.00                  | 0.00                   |
| 12   | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0.00                                   | 0.00                  | 0.00                   |
| 13   | Тайлант үеийн үр дүн                            | 2,052,610.00                           | 0.00                  | 2,052,610.00           |
| 14   | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 8,808,345.10                           | 0.00                  | 8,808,345.10           |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Код:        | Тайлангийн үзүүлэлт   | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-------------|---|------------------------|------------------------|
| <b>I</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>                 | <b>3,206,758.10</b>    | <b>4,822,984.40</b>    |
| <b>11</b>   | <b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>  | <b>1,497,604.80</b>    | <b>2,251,162.40</b>    |
| 110         | Орлогын албан татвар  | 954,952.50             | 1,714,345.00           |
| 1100        | Хувь хүний орлогын албан татвар                               | 1,049,201.20           | 1,809,267.90           |
| 1101        | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт               | (94,248.70)            | (94,922.80)            |
| 113         | Хөрөнгийн албан татвар  | 326,258.10             | 241,056.80             |
| 118         | Бусад татвар, төлбөр, хураамж                                 | 216,394.20             | 295,760.60             |
| 1180        | Бусад нийтлэг төлбөр, хураамж                                 | 15,715.20              | 19,184.80              |
| 1181        | Газрын төлбөр   | 171,240.90             | 275,805.40             |
| 1182        | Байгалийн нөөц ашигласны төлбөр                               | 29,438.10              | 770.30                 |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                    | <b>625,375.80</b>      | <b>631,668.50</b>      |
| 120         | Нийтлэг татварын бус орлого                                   | 625,375.80             | 631,668.50             |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                          | <b>1,083,777.50</b>    | <b>1,940,153.40</b>    |
| <b>II</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                      | <b>1,579,840.20</b>    | <b>2,182,484.80</b>    |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>1,579,840.20</b>    | <b>2,182,484.80</b>    |
| 210         | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                               | 1,539,643.60           | 2,125,771.60           |
| 2101        | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                             | 624,697.70             | 999,792.80             |
| 2102        | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                | 78,096.70              | 109,951.60             |
| 2103        | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                     | 82,235.20              | 549,781.30             |
| 2104        | Хангамж, бараа материалын зардал                              | 67,950.60              | 54,547.00              |
| 2105        | Нормативт зардал  | 2,100.00               | 2,100.00               |
| 2106        | Эд хогшил, урсгал засварын зардал                             | 45,383.00              | 67,321.50              |
| 2107        | Томилолт, зочны зардал  | 5,375.20               | 6,385.30               |
| 2108        | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж      | 567,077.80             | 223,971.90             |
| 2109        | Бараа үйлчилгээний бусад зардал                               | 66,727.40              | 111,920.20             |
| 213         | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  | 40,196.60              | 56,713.20              |
| <b>III</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>    | <b>1,626,917.90</b>    | <b>2,640,499.60</b>    |
| <b>V</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>              | <b>1,212,992.30</b>    | <b>1,816,918.50</b>    |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                       | <b>1,212,992.30</b>    | <b>1,816,918.50</b>    |
| 2200        | Дотоод эх үүсвэрээр   | 1,212,992.30           | 1,816,918.50           |
| <b>VI</b>   | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>  | <b>(1,212,992.30)</b>  | <b>(1,816,918.50)</b>  |
| <b>VII</b>  | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b> | <b>(175,000.00)</b>    | <b>(30,000.00)</b>     |
| <b>23</b>   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>             | <b>175,000.00</b>      | <b>30,000.00</b>       |
| <b>VIII</b> | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>      | <b>238,925.70</b>      | <b>793,581.10</b>      |
| 101         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл              | 704,095.30             | 943,021.00             |
| 20          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл             | 943,021.00             | 1,736,602.10           |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код  | Үзүүлэлт   | Төлөвлөгөө          | Гүйцэтгэл           | Зөрүү             | Хувь         |
|------|--|---------------------|---------------------|-------------------|--------------|
| II   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>4,624,737.60</b> | <b>3,987,002.39</b> | <b>637,735.21</b> | <b>86.2</b>  |
| 21   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>2,427,899.50</b> | <b>2,146,537.92</b> | <b>281,361.58</b> | <b>88.4</b>  |
| 210  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>2,326,918.30</b> | <b>2,089,824.74</b> | <b>237,093.56</b> | <b>89.8</b>  |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,073,414.00        | 999,792.79          | 73,621.21         | 93.1         |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 134,176.70          | 109,951.59          | 24,225.11         | 81.9         |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 562,117.70          | 549,781.34          | 12,336.36         | 97.8         |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 51,965.00           | 49,813.69           | 2,151.31          | 95.9         |
| 2105 | Нормативт зардал   | 2,162.40            | 2,100.00            | 62.40             | 97.1         |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 66,672.50           | 65,775.50           | 897.00            | 98.7         |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 9,409.20            | 6,385.30            | 3,023.90          | 67.9         |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 293,414.20          | 200,236.22          | 93,177.98         | 68.2         |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 133,586.60          | 105,988.31          | 27,598.29         | 79.3         |
| 213  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>100,981.20</b>   | <b>56,713.18</b>    | <b>44,268.02</b>  | <b>56.2</b>  |
| 22   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                  | <b>2,071,838.10</b> | <b>1,810,464.47</b> | <b>261,373.63</b> | <b>87.4</b>  |
| 23   | <b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>        | <b>125,000.00</b>   | <b>30,000.00</b>    | <b>95,000.00</b>  | <b>24.0</b>  |
| III  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>4,624,737.60</b> | <b>4,104,905.09</b> | <b>519,832.51</b> | <b>88.8</b>  |
| 32   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | <b>4,340,202.40</b> | <b>3,991,159.95</b> | <b>349,042.45</b> | <b>92.0</b>  |
| 35   | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>             | <b>284,535.20</b>   | <b>113,745.14</b>   | <b>170,790.06</b> | <b>40.0</b>  |
| 4    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 0                   | 198,104.79          | -198,104.79       | 0.0          |
| 5    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 0                   | 316,007.50          | -316,007.50       | 0.0          |
| 61   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                                  | <b>2</b>            | <b>2</b>            | <b>0.00</b>       | <b>100.0</b> |
| 62   | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>                                   | <b>39</b>           | <b>39</b>           | <b>0.00</b>       | <b>100.0</b> |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

| Код        | Үзүүлэлт   | ТЗ цэвэр дүн     |
|------------|--|------------------|
| <b>II</b>  | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>73,295.45</b> |
| <b>21</b>  | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>73,295.45</b> |
| <b>210</b> | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                   | <b>19,799.18</b> |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал                         | 4,733.33         |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 8,000.00         |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,134.00         |
| 2109       | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 5,931.85         |
| <b>213</b> | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                  | <b>53,496.26</b> |
| 2133       | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                            | 53,496.26        |
| <b>I</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                    | <b>73,295.45</b> |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого                              | 73,295.45        |

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын төсвийн төвлөрүүлэн захирагч *Цаашид Баянгол сумын ТТЗ гэх/ нь тайлант оны үйл ажиллагааны эрхэм зорилгыг "Өрхийн үйлдвэрлэл сумын хөгжил, хүлээж биш хүрч үйлчилье."* гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомжид дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2024 онд Баянгол сумын ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийж, ХХС-тай холбоотой зөвлөмж өгсөн бол төсвийн төвлөрүүлэн захирагчийн баталсан дотоод хяналтын төлөвлөгөөний дагуу ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаа болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянгол сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТТЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох

бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,875,006.3 мянган төгрөгөөр буюу 30.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| <i>/мянган төгрөгөөр/</i>                    |                    |                    |                     |
|--|--------------------|--------------------|---------------------|
| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт            |
| Б  | 1                  | 2                  | 3=2-1               |
| Мөнгөн хөрөнгө                               | 943,021.0          | 1,736,602.1        | 793,581.10          |
| Авлага                                       | 257,107.2          | 196,390.3          | -60,716.90          |
| Бараа материал                               | 837,807.2          | 1,556,591.6        | 718,784.40          |
| Үндсэн хөрөнгө                               | 4,784,836.4        | 5,385,422.3        | 600,585.90          |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>6,822,771.8</b> | <b>8,875,006.3</b> | <b>2,052,234.50</b> |
| Өр төлбөр                                    | 67,036.7           | 66,661.2           | -375.50             |
| Засгийн газрын хувь оролцоо                  | 6,755,735.1        | 8,808,345.1        | 2,052,610.00        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>6,822,771.8</b> | <b>8,875,006.3</b> | <b>2,052,234.50</b> |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудыг тус бүрээр нь тайлбарлан доор харуулав.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,736,602.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 793,581.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

| <i>/мянган төгрөгөөр/</i>  |                  |                    |                        |
|----------------------------|------------------|--------------------|------------------------|
| Үзүүлэлт                   | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл    | Өсөлт (+), Бууралт (-) |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 943,021.0        | 1,736,602.1        | 793,581.1              |
| Төрийн сангийн харилцах    | 943,021.0        | 1,736,602.1        | 793,581.1              |
| <b>Дүн</b>                 | <b>943,021.0</b> | <b>1,736,602.1</b> | <b>793,581.1</b>       |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 1,353,933.4 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 132,137.4 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 183,870.1 мянган төгрөг ХХС-ийн дансанд, 66,661.2 мянган төгрөг БХНС барьцаа дансанд тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 196,390.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 60,716.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

| Үзүүлэлт                                     | /мянган төгрөгөөр/ |                  |                        |
|--|--------------------|------------------|------------------------|
|  | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл  | Өсөлт (+), Бууралт (-) |
| Зээлийн хүүгийн авлага                       | 1,685.9            | 10,184.4         | 8,498.5                |
| Хувь хүмүүст олгосон зээл                    | 155,417.8          | 100,283.4        | -55,134.4              |
| Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | 100,003.5          | 85,922.5         | -14,081.0              |
| <b>Дүн</b>                                   | <b>257,107.1</b>   | <b>196,390.3</b> | <b>-60,716.9</b>       |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэлд ХХС-ийн зээлийн 186,205.9 мянган төгрөг, зээлийн хүүгийн 10,184.4 мянган төгрөгийн авлага тус тус тайлагнагдсан байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 1,556,591.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 718,784.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

| Үзүүлэлт                  | /мянган төгрөгөөр/ |                    |                        |
|---------------------------|--------------------|--------------------|------------------------|
|                           | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өсөлт (+), Бууралт (-) |
| Бичиг хэргийн материал    | 2,608.6            | 2,608.6            | 0.0                    |
| Аж ахуйн материал         | 2,365.5            | 2,198.3            | -167.2                 |
| Бусад хангамжийн материал | 737,833.1          | 1,436,784.7        | 698,951.6              |
| Мал амьтад                | 95,000.0           | 115,000.0          | 20,000.0               |
| <b>Дүн</b>                | <b>837,807.2</b>   | <b>1,556,591.6</b> | <b>718,784.4</b>       |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 718,784.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 148,750.0 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан, 240,680.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан зэргээс шалтгаалсан байна. /ОНХС-ийн хэрэгжээгүй төсөл арга хэмжээгээр нэмэгдсэн/

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,385,422.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 600,585.9 мянган төгрөгөөр өссөн байна. /үлдэх өртгөөр/

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                          | Эхний<br>үлдэгдэл  | Эцсийн<br>үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|-----------------------------------|--------------------|--------------------|---------------------------|
| Барилга, байгууламж, орон сууц    | 3,425,511.7        | 2,623,065.5        | -802,446.2                |
| Авто-тээврийн хэрэгсэл            | 27,432.4           | 302,168.0          | 274,735.6                 |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 229,952.5          | 161,070.7          | -68,881.8                 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил       | 28,527.8           | 21,146.9           | -7,380.9                  |
| Зам, гүүрийн байгууламж           | 465,235.6          | 1,143,791.8        | 678,556.3                 |
| Бусад үндсэн хөрөнгө              | 283,945.7          | 825,250.4          | 541,304.7                 |
| Дуусаагүй барилга, байгууламж     | 219,990.9          | 199,990.9          | -20,000.0                 |
| Программ хангамж                  | 684.4              | 468.7              | -215.6                    |
| Бусад биет бус хөрөнгө            | 103,555.4          | 108,469.4          | 4,914.0                   |
| <b>Дүн</b>                        | <b>4,784,836.4</b> | <b>5,385,422.3</b> | <b>600,585.9</b>          |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 600,585.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42.654.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ОНХС, ОНХО, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн 1,037,652.5 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан зэргээс голлон шалтгаалсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 66,661.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 375.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                 | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|--------------------------|-------------------|--------------------|---------------------------|
| Байгууллагад төлөх өглөг | 67,036.7          | 66,661.2           | -375.5                    |
| <b>Дүн</b>               | <b>67,036.7</b>   | <b>66,661.2</b>    | <b>-375.5</b>             |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд БХНС барьцаа дансанд байршуулсан 66,661.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг байгууллагад төлөх өглөгөөр тайлагнасан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 8,808,345.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,052,610.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт                         | Эхний<br>үлдэгдэл  | Эцсийн<br>үлдэгдэл | Өсөлт (+),<br>Бууралт (-) |
|----------------------------------|--------------------|--------------------|---------------------------|
| Засгийн газрын оруулсан капитал  | 1,264,860.6        | 1,264,860.6        | 0.0                       |
| Хуримтлагдсан үр дүн             | 4,014,236.5        | 6,066,846.5        | 2,052,610.0               |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,476,638.0        | 1,476,638.0        | 0.0                       |
| <b>Дүн</b>                       | <b>6,755,735.1</b> | <b>8,808,345.1</b> | <b>2,052,610.0</b>        |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Баянгол сумын ИТХ-ын “Сумын 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 110 дугаар тогтоолоор тайлант онд 1,581,627.0 мянган төгрөгийн татварын орлого, 365,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого зэрэг нийт **1,946,627.0** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **2,746,859.5** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 41.1 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөгөөр/

| Орлогын төрөл   | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл          | Зөрүү            | Хувь         |
|---|--------------------|--------------------|------------------|--------------|
| Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого | 1,016,376.7        | 1,443,115.5        | 426,738.8        | 142.0        |
| Үйл ажиллагааны орлого  | 150,000.0          | 299,327.9          | 149,327.9        | 199.6        |
| Хөрөнгийн орлого  | 5,000.0            | 48,482.5           | 43,482.5         | 969.7        |
| Хөрөнгө борлуулсны орлого   | 15,000.0           | 18,341.9           | 3,341.9          | 122.3        |
| ХХОАТ-ын буцаалт  | -94,922.8          | -94,922.8          | 0.0              | 100.0        |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар                                      | 60,000.0           | 108,969.3          | 48,969.3         | 181.6        |
| Бууны албан татвар  | 1,300.0            | 1,530.0            | 230.0            | 117.7        |
| Малд ногдуулах албан татвар   | 239,912.1          | 130,557.5          | (109,354.6)      | 54.4         |
| Улсын тэмдэгтийн хураамж  | 1,500.0            | 4,571.8            | 3,071.8          | 304.8        |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр                     | 669.0              | 694.0              | 25.0             | 103.7        |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж                                     | 12,000.0           | 13,919.0           | 1,919.0          | 116.0        |
| Газрын төлбөр   | 120,000.0          | 215,626.5          | 95,626.5         | 179.7        |
| Газрын дуудлага худалдаа  | 53,252.0           | 60,178.9           | 6,926.9          | 113.0        |
| Ойн нөөц ашигласны төлбөр   | 500.0              | 0.0                | (500.0)          | 0.0          |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр                                       | 40.0               | 0.3                | (39.7)           | 0.8          |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр                              | 1,000.0            | 770.0              | (230.0)          | 77.0         |
| <b>Татварын орлого</b>  | <b>1,581,627.0</b> | <b>2,251,162.3</b> | <b>669,535.3</b> | <b>142.3</b> |
| Торгуулийн орлого   | 335,000.0          | 463,041.3          | 128,041.3        | 138.2        |
| Бусад орлого  | 30,000.0           | 32,655.9           | 2,655.9          | 108.9        |
| <b>Татварын бус орлого</b>  | <b>365,000.0</b>   | <b>495,697.2</b>   | <b>130,697.2</b> | <b>135.8</b> |
| <b>Нийт орлогын дүн</b>   | <b>1,946,627.0</b> | <b>2,746,859.5</b> | <b>800,232.5</b> | <b>141.1</b> |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого 426,738.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 149,327.9 мянган төгрөгөөр, газрын төлбөр 95,626.5 мянган

төгрөгөөр, торгуулийн орлого 128,041.3 мянган төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

#### **Давж биелсэн орлогууд:**

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого: Тус суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын өмнөх оны санхүүгийн тайлангаар үүссэн өглөгийг барагдуулсан, Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор татварын орлого нэмэгдсэн,
- Үйл ажиллагааны орлого: Малчдад төрөөс ноос, сүү, улаан буудайн урамшуулал олгосон,
- Хөрөнгийн орлого: хадгаламжийн хүүгийн орлого нэмэгдсэн болон хувьцааны ногдол ашиг олгосон нь хүүгийн орлогыг нэмэгдүүлсэн,
- Газрын төлбөрийн орлого: Уул уурхайн компаниудын газрын төлбөрийн төлөлт болон өмнөх оны ер төлбөр барагдуулалт, хадлангийн төлбөрийн ногдуулалттай холбоотой,
- Торгуулийн орлого: Тус сумаар дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотойгоор торгуулийн ногдуулалт ихэссэн зэргээс шалтгаалсан байна.

#### **Тасарсан орлого:**

- Малд ногдуулах албан татвар: Өнгөрсөн онд тус суманд өвөлжилт хүндэрснээс малчдын санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлсөн бөгөөд сумын ИТХ-аар малын тоо толгойн албан татварыг 400 төгрөг болгож *12.0 мянган төгрөгийг*, бууруулж баталсан нь нөлөөлсөн байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төлөвлөхдөө аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг **1,726,766.4** мянган төгрөгөөр, татварын болон татварын бус орлогыг **1,237,470.1** мянган төгрөгөөр, өөрийн үйл ажиллагааны орлогыг **5,000.0** мянган төгрөгөөр зэрэг нийт эх үүсвэр, зарлагыг **2,969,236.5** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор:

- Татварын болон татварын бус орлогыг 2,007,431.4 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогыг 5,000.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс санхүүжих 407,000.0 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,577,832.9 мянган төгрөг,

- ОНХС-ын урьд оны үлдэгдлээс 148,805.2 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 28,808.0 мянган төгрөг,
- ХХС-ийн эхний үлдэгдлээс 101,922.0 мянган төгрөг,
- Аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 302,556.9 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг **4,579,356.4** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор тус сумын аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг бууруулсантай холбогдуулан сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 110 дугаар тогтоолоор:

- Орон нутгийн төсвийн орлогыг 60,804.4 мянган төгрөгөөр бууруулан 1,946,627.0 мянган төгрөг,
- Урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 38,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 445,200.0 мянган төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 5,000.0 мянган төгрөг,
- Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,646,920.8 мянган төгрөг,
- ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 148,805.2 мянган төгрөг,
- ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 28,808.0 мянган төгрөг,
- ХХС-ийн эхний үлдэгдлээс 101,922.0 мянган төгрөг,
- Аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 301,454.6 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, сумын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг **4,624,737.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр **4,624,737.6** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,427,899.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 2,071,838.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 125,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 301,454.6 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 2,746,859.6 мянган төгрөг, өөрийн орлогоос 6,496.0 мянган төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлгийг 1,589,278.6 мянган төгрөг, ХХС-ийн эргэн төлөлтийн 107,249.1 мянган төгрөг зэрэг нийт **4,751,337.9** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **3,987,002.4** мянган төгрөг буюу 86.2 хувьтай байгаа нь ХХС-ийн зээлийг гүйцэтгэлээр олгосон, урсгал зардлыг 281,361.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 261,373.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна. Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал нийт 97,846.3 мянган төгрөгөөр,

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 12,336.4 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардал 2,151.3 мянган төгрөгөөр,
- Нормативт зардал 62.4 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардал 897.0 мянган төгрөгөөр,
- Албан томилолт, зочны зардал 3,023.9 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 93,177.9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардал 27,598.3 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлэг 44,268.0 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн зардал 261,373.63 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 22 төсөл, арга хэмжээнд 2,035,638.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,774,264.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 273,196.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 3 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжихээр болсноос шалтгаалсан байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар 2 төсөл, арга хэмжээнд 36,200.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, зарцуулсан */ЗДТГ-т компьютер худалдан авах, өрөөнүүдийн хаалга солих зэрэг ажлуудыг гэрээ шууд байгуулах аргаар гүйцэтгэсэн/* байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс үзэсгэлэн худалдааны зардалд 418.6 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 2,272.1 мянган төгрөг, БТСГ-аас бүх нийтийн гүйлтийн тэмцээний зардалд 800.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 69,804.7 мянган төгрөг зэрэг нийт **73,295.4** мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнээс:

- Хангамж, бараа материалын зардалд 4,733.3 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 8,000.0 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 1,134.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардал 5,931.9 мянган төгрөг зэрэг нийт 19,799.2 мянган төгрөгийг зарцуулж, 53,496.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2,035,638.1 /343,287.3 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээ нь өмнөх оноос шилжиж ирсэн/ мянган төгрөгийн 22 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр харьцуулалтын аргаар гүйцэтгэх 6, нээлттэй тендер шалгаруулах 3 зэрэг нийт 9 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад бүрэн байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 9. Баянгол сумын 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан

/мянган төгрөгөөр/

| Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр | Төлөвлөсөн төсөл, арга хэмжээ |             | Үүнээс               |           |                    |           |     |             |
|------------------------------------|-------------------------------|-------------|----------------------|-----------|--------------------|-----------|-----|-------------|
|                                    |                               |             | Шууд гэрээ байгуулах |           | Харьцуулалтын арга |           | НТШ |             |
|                                    | Тоо                           | Дүн         | Тоо                  | Дүн       | Тоо                | Дүн       | Тоо | Дүн         |
| Сумын ОНХС                         | 19                            | 1,692,350.8 | 10                   | 199,000.0 | 6                  | 305,000.0 | 3   | 1,188,350.8 |
| Сумын ОНХО                         | 2                             | 36,200.0    | 2                    | 36,200.0  |                    |           |     |             |

Эх сурвалж: tender.gov.mn

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянгол сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн зардлын 2,016,840.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **20,168.4** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллагын зүгээс дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 97,846.3 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 12,336.4 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 2,151.3 мянган төгрөгөөр,
- Албан томилолтын зардлыг 3,023.9 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 93,177.9 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 27,598.29 мянган төгрөгөөр,
- Тус сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагддаг 6 автомашинд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй зэрэг төсвийн захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 49 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад хууль тогтоомжийг зөрчсөн нийт **3,879.6** мянган төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сумын Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс видео контент хийлгэхээр “Монголын баялаг өв соёл ХХК”-тай гэрээ байгуулан **3,879.6** мянган төгрөгийн төлбөр шилжүүлсэн боловч гэрээт ажлыг хүлээн аваагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага өгөх.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 11. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

| д/д | Байгууллагын нэр             | Мэдээлбэл зохих | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроосон |
|-----|------------------------------|-----------------|-----------------------|-------------------|
| 1   | Төсвийн төвлөрүүлэн захирагч | 171             | 165                   | 6                 |
| 2   | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 171             | 159                   | 12                |
| 3   | Засаг даргын Тамгын газар    | 171             | 160                   | 11                |
| 4   | Ойн анги                     | 171             | 171                   | 0                 |
|     | <b>Нийт дүн</b>              | <b>684</b>      | <b>655</b>            | <b>29</b>         |

Эх сурвалж: [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хөтөлбөр, арга хэмжээ нь тусдаа батлагдсан хэдий ч нийт дүнгээрээ худалдан авах босго үнээс /Хог хаягдал зайлуулах зардлаас 14,966.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлаас 7,537.9 мянган

төгрөг, үндсэн үйл ажиллагааны шатахууны зардлаас 14,998.1 мянган төгрөг, баг хорооны зардлаас 4,499.9 мянган төгрөг зэрэг нийт 42,002.3 мянган төгрөг/давсан шатахууны худалдан авалтыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь "... нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", Засгийн газрын 2024 онд батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтын 1-д "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар-Бараа 20.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах зөвлөмж хүргүүлэв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 172 дугаар "Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 дугаар улирлын санхүүгийн тайланд шинжилгээ хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4,559.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21,902.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 84,535.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өгөгдсөнөөс биелэлтийг аудитаар дахин хянахад 100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Имянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт  |                  |              |
|-----------------|------------------------|------------------|----------|------------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн              | Тоо      | Дүн              | Хувь         |
| Акт             | 1                      | 4,559.2          | 1        | 4,559.2          | 100.0        |
| Албан шаардлага | 4                      | 21,902.5         | 4        | 21,902.5         | 100.0        |
| Зөвлөмж         | 3                      | 84,535.3         | 3        | 84,535.3         | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>8</b>               | <b>110,997.0</b> | <b>8</b> | <b>110,997.0</b> | <b>100.0</b> |

Эх сурвалж: Баянгол сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах

ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа. Иймээс “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “ОНХС-ийн 2024 оны зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## **АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт **252,291.5** мянган төгрөгийн алдаа илэрснээс **46,283.6** мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, **206,007.9** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаанд зөвлөмж өглөө. Үүнд:

### **Залруулсан алдаа:**

- ИТХ нь 4,994.0 мянган төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан дансны ангиллыг мөнгөн гүйлгээний тайланд буруу бүртгэсэн,
- ИТХ нь үндсэн 4,129.4 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй,
- ЗДТГ нь 4,914.0 мянган төгрөгийн өртөг бүхий газрын дансны ангиллыг буруу бүртгэсэн,
- ЗДТГ нь үндсэн хөрөнгийн 32,246.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцоогүй гэх мэт.

### **Залруулаагүй алдаа:**

- ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,155.0 мянган төгрөгийн өртөг бүхий 3 ширхэг камер, 4,862.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 ширхэг зөөврийн компьютер, 3 ширхэг принтерийг тус тус орлогод аваагүй,
- ЗДТГ нь дуусаагүй барилга дансанд ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжиж дууссан 199,990.9 мянган төгрөгийн өртөгтэй халаалтын төвийн уурын зуухыг барилга, байгууламж дансанд шилжүүлж бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **58,001.1** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **5,754.0** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **40,093.2** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, **12,153.9** мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

### **5.1 Төлбөрийн акт:**

**5.1.1.** ЗДТГ нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны 8 албан хаагчид олгосон мөнгөн урамшууллаас нийт **5,335.3** мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй /10,11 дүгээр сард цалингаас 2,558.0 мянган төгрөгийг суутгаж авсан боловч шилжүүлээгүй/ байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1: “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө” 22.1.1: “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ХХОАТ-ыг нөхөн суутгаж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

**5.1.2.** ЗДТГ-т албан хаагчдын цалин хөлстэй холбоотой нийт **418.7** мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Ө.Сувд-Эрдэнэд хавсран ажилласны **196.2** мянган төгрөгийн нэмэгдлийг илүү тооцож, олгосон,
- Албан хаагчдыг аймаг, сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд албан томилолтын зардалтай давхардуулан хоолны хөнгөлөлт **222.5** мянган төгрөг тооцож, олгосон гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан болон илүү олгосон цалин, хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2. Албан шаардлага:**

**5.2.1.** Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас дараах зөрчлүүдийг гаргасан боловч санхүүгийн тайлант авлага, өр төлбөрөөр тусгаагүй **5,553.4** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- ИТХ нь ажилчдын цалингаас ХХОАТ-ыг суутгасан боловч төсөвт төвлөрүүлээгүйгээс **2,245.7** мянган төгрөгийн, ажил олгогчоос төлөх НДШ-ийг дутуу шилжүүлж, **619.2** мянган төгрөгийн өр төлбөр тус тус үүсгэсэн,
- ЗДТГ нь НДШ-ийг илүү шилжүүлж, **2,688.5** мянган төгрөгийн авлага үүсгэсэн гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ,” 14.4.3: “Бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь

*“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд ер төлбөрийг үнэн зөв тусгах, авлага, ер төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

**5.2.2.** Батлагдсан төсвийг зардлын бүлэг, эдийн засгийн ангилал болон хөтөлбөр хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй **12,874.5** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

**ИТХ нь нийт 4,635.7** мянган төгрөг:

- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 1,973.4 мянган төгрөг,
- Мэдээлэл сурталчилгааны арга хэмжээний зардлаас бараа үйлчилгээний бусад зардалд 780.0 мянган төгрөг,
- Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлаас урсгал засварын зардалд 1,296.8 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлс худалдан авахад 165.0 мянган төгрөгийг, бичиг хэргийн зардалд 420.5 мянган төгрөг гэх мэт.

**ЗДТГ нь нийт 8,238.8** мянган төгрөг:

- Багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлаас тавилга, эд хогшил худалдан авахад 1,460.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,042.5 мянган төгрөг,
- Урсгал засварын зардлаас багаж, техник хэрэгсэл худалдан авахад 2,800.0 мянган төгрөг,
- Бусад нийтлэг АҮТХ-аас даатгалын үйлчилгээнд 436.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 2,500.0 мянган төгрөг гэх мэт.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан *“Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.2.3.** Засаг даргын нөөц хөрөнгийн батлагдсан төсвөөс **21,665.3** мянган төгрөгийн зориулалт бус дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Сумын шинэ жилийн арга хэмжээнд 10,953.5 мянган төгрөг,

- Цагдаагийн шинэ барилгын зураг төсвийн магадлалын дүгнэлтэд 640.8 мянган төгрөг,
- Гэр хорооллын шороон замыг тэгшлүүлэх зардалд 3,511.0 мянган төгрөг,
- Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг иргэдэд хүргэх зорилгоор сэтгүүлийн хэвлэлийн төлбөрт 6,560.0 мянган төгрөг гэх мэт.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно.", 2 дугаар зүйлийн 2.1 дэх "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна:" 2.1.1: "хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, ... осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах", 2.1.2: "... зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах", 2.1.3: "тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль ... хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал", 2.1.4: "байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх", 2.1.5: "... урьдчилан төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ", 2.1.6: "шагнал, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **5.3.1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ЗДТГ нь анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан буюу "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-аар гүйцэтгэсэн ажлыг тодорхой тусгалгүйгээр илүү цагийн хөлсөнд /6-12 дугаар сард/ **12,153.9** мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон

үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.4 дэх "Төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын хавсралт хүснэгтийн үндэслэл хэсэгт 1.4.1-1.4.4, 1.5.1-1.5.2-т зааснаас тохирохыг сонгож бөглөнө. Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл бүрээр бичнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны хүчин төгөлдөр баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>1</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт алдаа |                  | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                 | Буруу тусган илэрхийлсэн |                  | Үүнээс     |                 |              |                  | Зөвлөмж  |                  |
|------------------|------------|------------------|-----------------------------------|-----------------|--------------------------|------------------|------------|-----------------|--------------|------------------|----------|------------------|
|                  |            |                  |                                   |                 |                          |                  | Залруулсан |                 | Залруулаагүй |                  |          |                  |
|                  | Тоо        | Дүн              | Тоо                               | Дүн             | Тоо                      | Дүн              | Тоо        | Дүн             | Тоо          | Дүн              |          |                  |
| ИТХ              | 2          | 9,123.4          | 1                                 | 4,129.4         | 1                        | 4,994.0          | 2          | 9,123.4         |              |                  |          |                  |
| ЗДТГ             | 4          | 243,168.1        | 2                                 | 37,108.2        | 2                        | 204,904.9        | 2          | 37,160.2        | 2            | 206,007.9        | 2        | 206,007.9        |
| <b>Дүн</b>       | <b>6</b>   | <b>252,291.5</b> | <b>3</b>                          | <b>41,237.6</b> | <b>3</b>                 | <b>209,898.9</b> | <b>4</b>   | <b>46,283.6</b> | <b>2</b>     | <b>206,007.9</b> | <b>2</b> | <b>206,007.9</b> |

/мянган төгрөгөөр/

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт зөрчил |                 | Төлбөрийн акт |                | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |                 | Хариуцлага тооцуулах албан шаардлага |     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |
|------------------|-------------|-----------------|---------------|----------------|-----------------|-----------------|----------|-----------------|--------------------------------------|-----|---|-----|
|                  |             |                 |               |                |                 |                 |          |                 |                                      |     |   |     |
|                  | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн            | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн             | Тоо                                  | Дүн | Тоо   | Дүн |
| ТТЗ              | 1           | 21,665.3        |               |                | 1               | 21,665.3        |          |                 |                                      |     |   |     |
| ИТХ              | 2           | 7,500.6         |               |                | 2               | 7,500.6         |          |                 |                                      |     |   |     |
| ЗДТГ             | 5           | 28,835.2        | 2             | 5,754.0        | 2               | 10,927.3        | 1        | 12,153.9        |                                      |     |   |     |
| <b>Дүн</b>       | <b>8</b>    | <b>58,001.1</b> | <b>2</b>      | <b>5,754.0</b> | <b>5</b>        | <b>40,093.2</b> | <b>1</b> | <b>12,153.9</b> |                                      |     |   |     |

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Байгууллагын нэр  | Нийт зөрчил   |                | Үүнээс          |     |          |                | Зөвлөмж  |
|---|---------------|----------------|-----------------|-----|----------|----------------|----------|
|   | Төлбөрийн акт |                | Албан шаардлага |     | Тоо      | Дүн            |          |
|   | Тоо           | Дүн            | Тоо             | Дүн |          |                |          |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b> |               |                |                 |     |          |                |          |
|   |               |                |                 |     |          |                |          |
| <b>Дүн</b>  |               |                |                 |     |          |                |          |
| <b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>                 |               |                |                 |     |          |                |          |
| ТТЗ-терийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн                     | 1             | 3,879.6        |                 |     | 1        | 3,879.6        |          |
| ЗДТГ -шатахууны тендер зарлаагүй                                | 1             |                |                 |     |          |                | 1        |
| <b>Дүн</b>  | <b>2</b>      | <b>3,879.6</b> |                 |     | <b>1</b> | <b>3,879.6</b> | <b>1</b> |
| <b>Нийт дүн</b>   | <b>2</b>      | <b>3,879.6</b> |                 |     | <b>1</b> | <b>3,879.6</b> | <b>1</b> |

/мянган төгрөгөөр/